



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/125

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх хэсэг, Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоол, Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 143 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Алагтолгой багийн 1 дүгээр гудамжны 45 тоот гэр бүлийн хэрэгцээний зориулалттай Зүгчигийн Отгонбаатар (пп66012610)-ын эзэмшлийн 1127 метр квадрат газрыг газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Батсүхийн Амаржаргал (пю95122548)-д шилжүүлж, хаягийг Баянбулаг 4 дүгээр гудамжны 422 тоот болгон 10 жилийн хугацаагаар,

2. Баатархайрхан баг, Тулгын улаан 30 айлын зүүн урд талд байрлах үйлчилгээний зориулалттай Дагвасүрэнгийн Мягмарцоож (пв73120418)-ийн эзэмшлийн 50 метр квадрат газрыг өв залгамжлах гэрээний дагуу Балжиннямын Отгонхишиг (пв74101001)-т шилжүүлж 5 жилийн хугацаатайгаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлэн авч, газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, ашиглаж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлэхийг дээрх иргэдэд үүрэг болгосугай.

4. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэдтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Э.Дөлбадрал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 0660
Zah A/125 Kh